



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ТАМГЫН ГАЗАР

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

Сэдэв: Нэмэлт, өөрчлөлтийн төсөл, санал дахь  
байгалийн баялаг, эдийн засгийн бусад асуудал

## ТАНИЛЦУУЛГА

ТӨРИЙН ОРДОН  
2019 он



# 1. БАЙГАЛИЙН БАЯЛАГ АРД ТҮМНИЙ МЭДЭЛД БАЙХ ЗАРЧМЫГ БЭХЖҮҮЛЖ, АШИГЛАЛТЫН ТОДОРХОЙ, ТОГТВОРТОЙ НӨХЦӨЛ БИЙ БОЛГОНО

## Үндсэн хуулийн заалт:

6.2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.

## Төслийн заалт:

6.2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан нь **НИЙТИЙН ӨМЧ** мөн.

## ШИНЭЭР НЭМЭГДСЭН:

Байгалийн баялагийг ашиглахдаа тэгш байдал, шударга ёс, үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах зарчим баримтална. Газрын хэвлийн баялагийг төрөөс олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр Монгол Улсын хуулийн этгээдэд энэ зүйлд заасан зарчмын дагуу ашиглуулж болно.

Онцгой ач холбогдол бүхий газрын хэвлийн баялагийг төр хамтран ашиглах тохиолдолд гарах зардлыг хөрөнгө оруулагч хариуцах бөгөөд татварын дараах ашгийн тавин нэгээс доошгүй хувь нь Монгол Улсын төрд ногдоно. Хөрөнгө оруулагчийн зардал бодитой байна. Хөрөнгө оруулагчийн зардалд төр хяналт тавьж ард түмэнд тайлагнана.

Газрын хэвлийн баялагийг хөрөнгө оруулагчтай хамтран ашигласны орлогыг баялагийн санд төвлөрүүлж, зарцуулна. Байгалийн баялагийг ашиглах болзол, баялагийн сангийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.



## 2. ГАЗРЫГ НЭГДСЭН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ АШИГЛАХ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ



### Төслийн заалт:

6.6. Нийтийн өмчийн газрыг Монгол Улсын иргэнд **өмчлүүлэх**, иргэн, хуулийн этгээдэд тодорхой хугацаагаар **эзэмшүүлэх** буюу **ашиглуулах** шийдвэрийг хуульд заасан болзол, журмын дагуу **зөвхөн Засгийн газар, аймаг, хот, нийслэлийн Засаг дарга /Захирагч/ гаргана.**



### 3.ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ХАРААТ БУСААР АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, БАТАЛГААГ БҮРДҮҮЛНЭ



#### Төслийн заалт:

19<sup>21</sup>.Монгол Улс төв банктay байна. Төв банк нь хараат бус, бие даасан байгууллага байх бөгөөд Монголбанк гэж нэрлэнэ.

19<sup>22</sup>.Монголбанк нь төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах болон санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлж, төрийн эрдэнэсийн санг эрхлэн удирдана.

19<sup>23</sup>.Монголбанкны үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.



## 4.УЛС ОРНЫХОО ТУСГААР ТОГТНОЛ, НУТАГ ДЭВСГЭРИЙН БҮРЭН БҮТЭН БАЙДЛЫН ХАМГААЛАЛТЫГ БЭХЖҮҮЛЖ, БАТАТГАНА

*25.1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:*

### **Үндсэн хуулийн заалт:**

25.1.6.ард нийтийн санал асуулга явуулах. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ.

### **Төслийн заалт:**

25.1.6.ард нийтийн санал асуулга явуулах. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ. **Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд ийм санаархал бүхий ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно;**



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ТАМГЫН ГАЗАР

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА